



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 414

Улаанбаатар хот

Г “Дархан хүнс” ХК-ийн үнэт цаасны  
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Т

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3, Компанийн тухай хуулийн 25 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дархан хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Батнасан, Д.Бат-Эрдэнэ, Б.Одонцэцэг, С.Оюунчимэг, Б.Бат-Өлзий нараас “Дархан хүнс” ХК-д олгосон нийт 615,213,981 /зургаан зуун арван таван сая хоёр зуун арван мянга есөн зуун наян нэг/ төгрөгийн зээлийн өрийн нэгж хувьцаанд хөрвөх үнийг 2564 /хоёр мянга таван зуун жаран дөрөв/ төгрөгөөр тооцон тус бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 239,943 /хоёр зуун гучин есөн мянга есөн зуун дөчин гурав/ ширхэг энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. “Дархан хүнс” ХК-ийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 13/02 дугаар тогтоолд заасны дагуу нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог нийт 239,943 /хоёр зуун гучин ес мянга есөн зуун дөчин гурав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
3. Нэмж гаргасан 239,943 ширхэг хувьцаанаас хувьцаа эзэмшигч Б.Батнасанд 14,660 ширхэг, Д.Бат-Эрдэнэд 29,633 ширхэг, Б.Одонцэцэгт 46,790 ширхэг, С.Оюунчимэгт 33,160 ширхэг, Б.Бат-Өлзийд 115,700 ширхэгийг хувиарлаж тус тус өмчлөх эрхийг баталгаажуулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
4. “Дархан хүнс” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус компани /А.Тунгалаг/-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:
  - 1/ Хаалттай хүрээнд үнэт цаас нэмж гаргасантай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хуралд оролцоогүй болон уг асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчдэд компанийд өөрийн эзэмшиж буй хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн болохыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдэгдэх;
  - 2/ Нэмж үнэт цаас гаргах ажиллагааг хэрэгжүүлж дууссанаас хойш гүйцэтгэлийн тайланг 30 хоногийн дотор тус Хороонд ирүүлэх, мөн уг тайланг нийтэд мэдээлэх;

00 780

3/ Цаашид хувьцаанд хөрвөх нөхцөлтэйгөөр бусдаас аливаа санхүүжилт авч өр үүсгэхээс өмнө асуудлыг урьдчилан Хороонд танилцуулан шийдвэрлүүлж, гарсан шийдвэр, өр төлбөр үүсч буй явцын талаар нийтэд тухай бүр шуурхай мэдээлэхээс гадна өр төлбөрийн гүйлгээг заавал компанийн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байх;

4/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

